


Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр ..... цаг



- Багш, гэр бүлийн гишүүд нь асуултыг уншиж, сурагчид дасгал, даалгаврыг бие даан гүйцэтгэнэ үү.
- Бид хичээлийн хэрэглэл, эд зүйлсийг ангилж, зөв хэрэглэж сурсан уу?

Даалгавар

1 Эдгээр дэвтрийг ямар хичээлд хэрэглэж болохыг холбон зураарай.



2 Сурагчийн дүрэмт хувцсыг улаан өнгийн харандаагаар, биеийн тамирын хувцсыг цэнхэр өнгийн харандаагаар будаарай.



Дууссан .....он .....сар .....өдөр.....цаг

☑ Өөрийн үнэлгээ: 🟡 🟡



Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар .....өдөр.....цаг




Жижиг зүйлийг олон давтан хийх нь гарын жижиг булчинг хөгжүүлдэг. Тухайн зүйлийг давтан хийх нь алдаагүй зөв хийж сурахад тусалдаг. Бид хичээлийн хэрэглэгдэхүүнээ зөв сонгож, хэрэглэж чаддаг уу?

Даалгавар

1 Дараах дүрс ба зурлагыг тохирох дэвтэрт зурж бичнэ үү.



2 Энэ 3 дүрсийг эхлээд шугам хэрэглэхгүйгээр дараа нь шугам хэрэглэн зураарай.



3 Дүрсийг ижил зурсан уу?  
А.тийм      Б.үгүй  
Ялгаатай зурсан уу?  
А.тийм      Б.үгүй  
Аль нь хялбар байсан бэ?  
А. Шугам хэрэглэхгүй зурах      Б. Шугам хэрэглэж зурах

Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар .....өдөр.....цаг



Мэдрэх, сонсох, амтлах, үнэрлэх, харах нь хүний үндсэн мэдрэхүй юм. Хүн нүдээрээ юмсын өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөн байршлыг харж мэдэрдэг бол чих, гарын арьс, хэл юуг мэдэрч болох вэ? Өдрийн дэглэм гэж юуг хэлэх вэ?

Даалгавар

1

Хүн дараах зүйлсийг ямар эрхтний тусламжтайгаар мэдрэх вэ? Зөв холбон зураарай.



2

Үнэртэй ус, цэвэр усыг харахгүйгээр мэдрэхүйн ямар эрхтнүүдийн тусламжтай ялган таних вэ? Доорх хоосон зайд зурна уу?



Үнэртэй ус



Цэвэр ус




Доорх QR кодыг уншуулж мэдлэгээ бататгаарай.



3

Нарны байрлал, өдөр тутам хийх үйлийг холбон зураарай.



Дууссан .....он .....сар .....өдөр....цаг



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр ..... цаг



Хүний биеийн мэдрэхүйн эрхтний үүргийг туршилт хийж тайлбарлаарай. Бид өдөр тутамдаа эрүүл ахуйн болон аюулгүй ажиллагааны дэглэм баримталдаг уу? Тэрхүү дэглэмээ дадал, зуршил болгож чадсан уу? Эргэцүүлж бодоорой.

Даалгавар

1 Туршилтын үр дүнг ямар эрхтний тусламжтайгаар мэдрэх вэ? Дугуй дүрсийг будаарай.

Туршилт: Дараах зүйлсийг ашиглан туршилт хийгээрэй.

Халбага

Ус

Давс

2 Өглөөнөөс орой хүртэлх нэг өдрийг юу хийж өнгөрүүлдэг вэ? Зургийг ажиглан дарааллаар нь дугаарлана уу?

Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг ямар материалаар хийсэн вэ? Хичээлийн хэрэглэгдэхүүнийг хийсэн материалын шинж чанараар нь ялгаж чадах уу? Зарим зүйлийг туршиж үзээд даалгаврыг гүйцэтгээрэй.

Даалгавар

1 Дараах хичээлийн болон сургалтын хэрэглэгдэхүүнийг ямар материалаар хийсэн байна вэ? Зөв харгалзуулаарай.

А. Мод



Б. Даавуу



В. Цаас



Г. Төмөр



Д. Хуванцар



2 Дээрх хичээлийн хэрэглэгдэхүүний аль нь соронзод татагдах вэ?



Туршилт

Сургалтын хэрэглэгдэхүүний аль нь соронзод татагдаж байгааг туршиж үзээрэй.

Соронзод татагдаж байгаа хичээлийн хэрэглэгдэхүүнийг тоочин бичээрэй.

.....  
.....  
.....  
.....

3 Бичлэгийг үзнэ үү. [https://www.youtube.com/watch?v=8\\_QPmzNMmrQ&t=58s](https://www.youtube.com/watch?v=8_QPmzNMmrQ&t=58s) Нэг хичээлийн хэрэглэгдэхүүн сонгож, түүнийг ариг гамтай хэрэглэх талаар өөрийн бодлоо бичээрэй.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....



Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр.....цаг




Сургалтын хэрэглэгдэхүүнийг ямар шинж чанартай болохыг нь мэдэх үү? Хичээлийн хэрэглэгдэхүүнийг хэрхэн цэвэрхэн хэрэглэх талаар бодож байсан уу? Ажиглаж, туршаад даалгавраа хийгээрэй.

Даалгавар

1 Дараах зааврыг уншаад, тохирох сургалтын болон хичээлийн хэрэглэгдэхүүний нэрсийг хоосон зайд бичээрэй.

- 1. Нугалж болохгүй. ....
- 2. Заавал таглаж хадгална. ....
- 3. Угааж цэвэрлэж хэрэглэнэ. ....
- 4. Ус хүргэж болохгүй. ....

2 Дээрх хичээлийн хэрэглэгдэхүүнүүд ямар шинжтэй байна вэ? (зөөлөн хэврэг, соронзлогддог, бат бөх, ус шингээдэг, уян хатан гэх мэт)




3 Зааврын дагуу дараах туршилтыг хийж, үр дүнгийн талаар ярилцаарай.

Заавар

Хоёр шилэн аягатай усанд дэвтрийн цаас болон уугч цаас хийж хутгаарай.



Уугч цаас



Дэвтрийн цаас





Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Хүний биеийн бүтцийн хэсгүүд, тэдгээрийн үүргийг тайлбарлаж чадах уу? Гэмтэж бэртэхгүй байхын тулд хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллаарай.

Даалгавар

1

Доорх зурагт хүний биеийн бүтцийн хэсгүүдийг харуулжээ. Хүний толгой, их бие, хөлийн нүдэнд харагдах хэсгийг нэрлэн бичээрэй.








Толгойн хэсэг

Их биеийн хэсэг

Доод мөчдийн хэсэг


2

Зурагт үзүүлсэн хүний биеийн бүтцийн хэсгүүдийн үүргийг тайлбарлаж бичнэ үү?



3

Зургуудыг ажиглаарай. Ажил хөдөлмөр эрхлэх явцад аюулгүй ажиллах ямар арга байгааг нэг өгүүлбэрээр илэрхийлэн бичээрэй.



Дууссан .....он .....сар .....өдөр....цаг



Өөрийн үнэлгээ:




Сурагчийн нэр ..... Эхэлсэн ..... он ..... сар ..... өдөр.....цаг





Хүний гар, хөлийн хурууны байрлал, үүрэг нь ижилхэн үү, ялгаатай юу ?  
Сандал дээр зөв сууж хэвших нь ямар ач тустай вэ?  
Ажиглаж, туршаад даалгавраа хийгээрэй.

**Даалгавар**

- 1 Гарын таван хуруугаа нэрлэн бичээд , дууг доорх линк болон QR код ашиглан даган дуулаарай. <https://www.youtube.com/watch?v=C5I4hmF-uDU>



- 2 Гар, хөлийн хуруунууд хоорондоо ялгаатай юу? Адил болон ялгаатай шинжийг бичээрэй.

	Ижил тал	Ялгаатай тал
Гарын хуруу 		
Хөлийн хуруу 		

- 3 Зургийг ажиглаад, буруу сууснаас хүний биед үүсч болзошгүй өөрчлөлтийг нэрлэн бичээрэй.





Сурагчийн нэр: .....


Эхэлсэн: ..... он .....сар .....өдөр....цаг



“Би” бүлэг сэдвийн хүрээнд даалгаврыг хийж гүйцэтгэх явцдаа байгаль, нийгэмтэй харилцан өөрийгөө нээн таних, эрүүл аж төрөх дадал хэвшилд суралцаарай. Амьд ба амьгүй биеийн ялгаа юу вэ?

Даалгавар

1 Зургийг ажиглаад амьд болон амьгүй биеийг ялган нэрлэж бичээрэй.



2 Бидний өдөр тутам иддэг ургамлын гаралтай бүтээгдэхүүний нэрийг ногоон өнгөөр, амьтны гаралтай бүтээгдэхүүний нэрийг шар өнгөөр будаарай.



Сонгино

Загасны мах

Саримс

Лууван

Өндөг

Үхрийн мах

Байцай

Тахианы мах

Өргөст хэмх



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Амьд бие идэш тэжээлээ олж авах, аюулаас өөрийгөө хамгаалахын тулд хөдөлгөөн хийдэг. Амьтад ямар, ямар хөдөлгөөн хийдэг вэ?

3 Дараах амьд биесүд яагаад хөдөлгөөн хийсэн бэ? Шалтгааныг тайлбарлаарай. Ямар хөдөлгөөн хийж буйг нэрлэн бичээрэй.



Хөдөлгөөн хийсэн учир шалтгаан: .....

Хөдөлгөөний хэлбэрүүд



4 Хүн хооллох, амьдрах хэрэгцээгээ хангах үүднээс олон янзын хөдөлгөөн, ажил хөдөлмөр эрхэлдэг. Зургийг ажиглаад хөдөлгөөний хэлбэрүүдийг нэрлэж бичээрэй.



Four empty boxes for labeling the activities shown in the images above.

5 Дараах зургийг ажиглан асуултыг уншаад өөрийн бодлыг хүснэгтэд тайлбарлан бичээрэй.

		<p>Хээрийн балжингарав цэцэг маш гоё ургаж байна. Гэтэл найзтайгаа хийсэн цаасан цэцэг ерөөсөө ургадаггүй.</p>	<p>Миний бодлоор .....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
		<p>Нугас шувуу идэш тэжээлээ өөрөө олж иддэг. Харин миний тоглоомон нугас шувуу хоол иддэггүй.</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
		<p>Миний тэжээсэн загас маш том болж бас олон болсон. Гэтэл тоглоомон загас маань том болдоггүй бас ганцаараа л байдаг</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: .....он ..... сар ..... өдөр....цаг



Амьд биеийн онцлог шинж юу вэ? Хүн, амьтан, ургамал нь хөдлөх, хооллохоос гадна үрждэг, мэдэрдэг, амьсгалдаг шинжээрээ ижил байдаг.

1 Зургийг ажиглаад хүн, амьтан, ургамлын ижил шинжийг бичээрэй.



.....

2 Зургийг ажиглаад амьтдын үр төлийг зөв харгалзуулаарай.



- 1. Могой
- 2. Загас
- 3. Хонь
- А. Түрс шахна
- Б. Амьд зулзага төрүүлнэ
- В. Өндөглөнө

3 Мэлхийн өсөлт, хөгжлийн үе шатыг зөв дараалалд оруулж дугаарлаарай. Нас бие гүйцсэн мэлхий аль нь вэ? /хайчлаад нааж болно/





Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг




Бид тэжээллэг хоол хүнс хэрэглэж чадаж байгаа юу? Тэжээллэг хоол хүнс хэрэглэх нь ямар ач тустай вэ? Хүний өдөр тутам хэрэглэдэг хоол хүнсийг өсөлтийн, илчлэгтэй, амин дэмтэй хоол хүнс гэж ангилдаг.

1 Бид хоол хүнсээ худалдан авахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?

-**Үйлдвэрлэсэн хугацаа**,.....  
.....  
.....

2 Эдгээр хүнснээс өөрт хэрэгтэй илчлэг, аминдэмтэй хүнсний нэрийг бичээд сагсанд ялгаж хийгээрэй



**Аминдэмтэй**



**Илчлэгтэй**

3 Эхийг уншаад асуултад хариулаарай.

Бага насны хүүхдийн хоол тэжээл төрөл бүрийн аминдэм, эрдэс бодисоор баялаг байх хэрэгтэй. Хоол хүнсний илчлэг, аминдэмийн дутагдлаас болж бага насны хүүхэд өсөлтийн хоцрогдолд орох, оюуны чадамж сулран, биеийн дархлаа муудахаас гадна сульдаа болон бусад олон төрлийн өвчинд нэрвэгддэг байна. Хүүхдийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэгтэй А аминдэмийн хэрэгцээг цэцгийн тос, зөөхий, загас, хүнсний ногоо зэргээс авах боломжтой байдаг. Харин хүүхдийн ясны бэхжих үйл явцыг дэмжих Д аминдэмийг авахад сүү цагаан идээ, өндөг, загасны тос, загасны түрс гэх мэт хоол хүнснээс авдаг байна.

1.Хүүхдийн өсөлтийг дэмждэг хүнсний бүтээгдэхүүнийг нэрлээрэй.

.....  
.....

2.Хүүхдийн яс бэхжихэд нөлөөлдөг хүнсний бүтээгдэхүүнийг нэрлээрэй

.....  
.....

4 Цэгийн оронд тохирох үгийг гүйцээж бичээрэй. (эрдэс бодис, амин дэм, илчлэг)

Бид өдөр тутмын хоол хүнсэндээ шинэхэн жимс, ногоог хэрэглэснээр бие махбодод шаардлагатай ..... -ийг авах боломжтой.

